"Монголын Хөрөнгийн бирж" ТӨХК-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын төслийн 1 дүгээр хавсралт

# БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Энэхүү тайлан нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компаниудын байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын чиглэлээр тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн стратеги, арга хэмжээ, нөхцөл байдлыг хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, олон нийтэд ил тод нээлттэй тайлагнах зорилготой.

Хэсэг 1, 2, 3 нь нийт үнэт цаас гаргагч компаниудад хамааралтай бөгөөд Хэсэг 4 нь зөвхөн тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй үнэт цаас гаргагчдад хамаарна.

Хэрэв тайлангийн маягтад заасан аливаа мэдээллийг цуглуулах, тайлагнах боломжгүй бол тайлагнах боломжтой талаарх тайлбар, цаашид мэдээллийг тайлагнах чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар 'тайлбар' хэсэгт бичнэ үү.

| | |
|---|---|
| **Огноо (он, сар, өдөр):** | **11/7/2023** |
| **Үнэт цаас гаргагчийн нэр:** | **"ХААН Банк" ХК** |
| **Үнэт цаасны нэр, код (МХБ симбол):** | **KHAN** |
| **Салбарын ангилал:** | **Санхүү** |
| **Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон толгой болон охин компаниудын мэдээлэл):** | |
| **Тайлангийн хамрах хугацаа:** | **2022.01.01-2022.12.31** |
| **Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих имэйл хаяг, утас:** | **М. Мандахмягмар, Тогтвортой хөгжлийн газрын захирал /99048934/ sustainability@khanbank.com** |
| **Тайланг баталгаажуулсан гүйцэтгэх удирдлагын мэдээлэл (нэр, албан тушаал):** | **Р.Мөнхтуяа, Гүйцэтгэх захирал** |
| **Гүйцэтгэх удирдлага эсвэл ТУЗ-ийн даргын гарын үсэг:** | |

| | Бүлэг | Шалгуур үзүүлэлт | | Үзүүлэлт (өмнөх он) | Үзүүлэлт (тайлант он) | Хэмжих нэгж | Нэмэлт мэдээлэл | Тайлбар | Холбоос |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | агын системтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд | | | | | | | | |
| MS1.1 | | Удирдлагын амлалт | Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх | | Тийм | | ХААН Банк 2010 онд НҮБ-ын дэргэдэх Даян дэлхийн гэрээний 4 бүлэгт 10 зарчмыг дагаж мөрдөх амлалтаа илэрхийлсэн байдаг. Түүнчлэн 2013 онд Монголын ТоС-ын 8 зарчмыг хэрэгжүүлэхээ илэрхийлсэн. Эдгээрийг хэрэгжүүлэх болон МУ-ын Тогтвортой санхүүгийн үндэсний замын зургийн хүрээнд 2025 он гэхэд банкныхаа нийт зээлийн багцын 10%-ийг, 2023 онд 5%-ийг ногоон зээлийн багцаар бүрдүүлэхийг зорин ажиллаж байна. | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 102 |
| MS2.1 | | Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт | Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх | | Тийм | | https://www.khanbank.com/personal/about/sustainable-development-policy/ | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 103, ISO 14001 |
| MS2.2 | | | Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх | | Тийм | | 2013 онд ХААН Банк Тогтвортой санхүүжилтийн 8 зарчмыг хэрэгжүүлэх ТоС ажлын хэсэг байгуулж байсан ба үүнийг 2019 онд Тогтвортой хөгжлийн ажлын хэсэг болгон өргөжүүлэн байгуулсан. 2022 онд тус ажлын хэсгийг Тогтвортой хөгжлийн үндсэн ба дэд ажлын хэсэг болгон төрөлжүүлж зохион байгуулсан. Үндсэн ажлын хэсэг Гүйцэтгэх удирдлагын түвшний захирлуудаас бүрдэх ба 4 дэд ажлын хэсэгт Тогтвортой санхүүжилт, Тогтвортой үйл ажиллагаа, Тогтвортой ажлын байр болон Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт хэмээн хуваагдаж чиглэл тус бүрийн асуудлыг хэлэлцэн, шийдвэр гаргах үйл ажиллагаа зохион байгуулагдана. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн 2022 оны тайлангийн 32-р хуудаснаас үзнэ үү. | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 103, ISO 14001 |
| MS3.1 | | Бүтэц удирдлага | ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх | | Тийм | | Банкны ТУЗ-ийн дэргэдэх Компанийн засаглалын хороо нь банкны Тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хянан, хагас жил тутам тайлагнадаг ба тус хорооны гишүүд уг асуудлыг хариуцан ажилладаг. | | GRI 102 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| MS3.2 | | | Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх | | Тийм | | ХААН Банкны Гүйцэтгэх захирал банкны Тогтвортой хөгжлийн асуудлыг хариуцан ажилладаг буюу Тогтвортой хөгжлийн газрыг шууд удирдлагаар хангах, Тогтвортой хөгжлийн үндсэн ажлын хэсгийг ахлан ажилладаг. | | GRI 102 |
| MS3.3 | | | Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх | | Тийм | | ХААН Банкны байгууллагын бүтцэд 2022 оны 5-р сард Тогтвортой хөгжлийн газрыг шинээр байгуулж, холбогдох асуудлыг хариуцан ажилладаг. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 102 |
| MS3.4 | | | Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг уу? | | Тийм | | Банкны ТУЗ-ийн дэргэдэх Компанийн засаглалын хороо нь банкны Тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хянан, хагас жил тутам тайлагнадаг. Тус хорооны гишүүд уг асуудлыг хариуцан ажилладаг ба ТУЗ-ийн хурлаар тухай бүр асуудлыг хэлэлцдэг. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 102 |
| MS3.5 | | Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ | Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх | | Тийм | | 2022 онд ХААН Банк ОУ-ын үнэлгээний байгууллагаар БОНЗ-ын үнэлгээ хийлгэсэн ба үр дүнд үндэслэн 2023 оны 1-р сард оролцогч талуудын оролцоог хангасан нөлөөллийн болон чухал байдлын матрицтай болсон. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн тайлангийн 25-р хуудаснаас үзнэ үү. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | SASB |
| MS4.1 | **Тогтвортой хөгжлийн удирдлагын систем** | Чадавх бүрдүүлэлт | Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хуйсээр | | 10 | минут | Банкны сургалт, хөгжлийн төлөвлөгөөнд Тогтвортой хөгжлийн сургалтыг тусган оруулсан ба шинэ ажилтны болон нийт ажилтны тухайн жилд ЗААВАЛ ҮЗЭХ сургалтын агуулгад тусган оруулсан. Тус сургалтад тайлант хугацаанд нийт 1,622 ажилтан хамрагдсан. Заавал үзэх сургалт 7 дэд сэдвээс бүрддэг. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн тайлангийн 58-р хуудаснаас үзнэ үү. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 102 |
| MS4.2 | | Хяналт | Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу? | | Тийм | | 1. Банк дотоод хяналтын бодлогоо ОУ-д хүлээн зөвшөөрөгдсөн COSO загварт үндэслэн боловсруулж ТУЗ-өөр батлуулсан. Энэхүү бодлогын үндэслэл болох COSO загварын хяналтын орчны бүрэлдэхүүн хэсэг нь банкны дотоод хяналтыг шударга байдал, ёс зүй, үнэт зүйл, зохион байгуулалт, тайлагналын шугамын зохистой бүтэц, ажилтнуудын ур чадварын бодлого, урамшууллын бодлоготой уялдуулсан үзүүлэлтүүдээр үнэлж хэмжиж, эрсдэлийн удирдлагаа хэрэгжүүлдэг.<br>2. Дотоод аудит (ДА)-ын дүрэмд ДА нь банкны засаглал, эрсдэл, хяналтын үйл ажиллагаанд баталгаажуулалтын болон зөвлөх аудитын үйлчилгээ үзүүлэхээр тусгагдсан байдаг ба дүрмийг Ажлын хэсэг баталдаг. Энэ чиг үүргийн хүрээнд банкны засаглалын зарчим, эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоо нь банкны тогтвортой, урт хугацааны үр ашигтай бизнесийн үйл ажиллагаанд зохистой бөгөөд нийцтэй байгаа эсэх баталгаажуулалтуудыг хийж ажиллаж байна. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн тайлангийн | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 102, SDG 12 |
| MS4.3 | | | Танай компани тогтвортой байдал/хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу? | | Тийм | | ХААН Банк нь 2018 оноос хойш Тогтвортой хөгжлийн тайланг тусад нь тайлагнасаар байна.<br>Дэлгэрэнгүйг ХААН Банкны цахим хуудаснаас үзнэ үү. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 102, SDG 12 |
| MS5.1 | | Тогтвортой байдлын тайлагнал | Танай компани олон улсын уур амьсгалын эрсдэлийн стандартын дагуу тайлагнадаг уу? | | Үгүй | | | ТХ-ийн 17 зорилго, Даян дэлхийн гэрээний 10 зарчим, ToC-ийн 8 зарчмын хүрээнд 2019 оноос хойш тайлагнаж байна. 2023 онд банк Эрсдэлийн удирдлагадаа Уур амьсгалын эрсдэлийг тодорхойлон оруулсан ба цаашид уг эрсдэлийг удирдах төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. | GRI 102, SDG 12 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| MS3.2 | | | Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх | | Тийм | | ХААН Банкны Гүйцэтгэх захирал банкны Тогтвортой хөгжлийн асуудлыг хариуцан ажилладаг буюу Тогтвортой хөгжлийн газрыг шууд удирдлагаар хангах, Тогтвортой хөгжлийн үндсэн ажлын хэсгийг ахлан ажилладаг. | | GRI 102 |
| MS3.3 | | | Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх | | Тийм | | ХААН Банкны байгууллагын бүтцэд 2022 оны 5-р сард Тогтвортой хөгжлийн газрыг шинээр байгуулж, холбогдох асуудлыг хариуцан ажилладаг. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 102 |
| MS3.4 | | | Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг уу? | | Тийм | | Банкны ТУЗ-ийн дэргэдэх Компанийн засаглалын хороо нь банкны Тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хянан, хагас жил тутам тайлагнадаг. Тус хорооны гишүүд уг асуудлыг хариуцан ажилладаг ба ТУЗ-ийн хурлаар тухай бүр асуудлыг хэлэлцдэг. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 102 |
| MS3.5 | | Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ | Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх | | Тийм | | 2022 онд ХААН Банк ОУ-ын үнэлгээний байгууллагаар БОНЗ-ын үнэлгээ хийлгэсэн ба үр дүнд үндэслэн 2023 оны 1-р сард оролцогч талуудын оролцоог хангасан нөлөөллийн болон чухал байдлын матрицтай болсон. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн тайлангийн 25-р хуудаснаас үзнэ үү. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | SASB |
| MS4.1 | **Тогтвортой хөгжлийн удирдлагын систем** | Чадавх бүрдүүлэлт | Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр | | 10 | минут | Банкны сургалт, хөгжлийн төлөвлөгөөнд Тогтвортой хөгжлийн сургалтыг тусган оруулсан ба шинэ ажилтны болон нийт ажилтны тухайн жилд ЗААВАЛ ҮЗЭХ сургалтын агуулгад тусган оруулсан. Тус сургалтад тайлант хугацаанд нийт 1,622 ажилтан хамрагдсан. Заавал үзэх сургалт 7 дэд сэдвээс бүрддэг. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн тайлангийн 58-р хуудаснаас үзнэ үү. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 102 |
| MS4.2 | | Хяналт | Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу? | | Тийм | | 1. Банк дотоод хяналтын бодлогоо ОУ-д хүлээн зөвшөөрөгдсөн COSO загварт үндэслэн боловсруулж ТУЗ-өөр батлуулсан. Энэхүү бодлогын үндэслэл болох COSO загварын хяналтын орчны бүрэлдэхүүн хэсэг нь банкны дотоод хяналтыг шударга байдал, ёс зүй, үнэт зүйл, зохион байгуулалт, тайлагналын шугамын зохистой бүтэц, ажилтнуудын ур чадварын бодлого, урамшууллын бодлоготой уялдуулсан үзүүлэлтүүдээр үнэлж хэмжиж, эрсдэлийн удирдлагаа хэрэгжүүлдэг.<br>2. Дотоод аудит (ДА)-ын дүрэмд ДА нь банкны засаглал, эрсдэл, хяналтын үйл ажиллагаанд баталгаажуулалтын болон зөвлөх аудитын үйлчилгээ үзүүлэхээр тусгагдсан байдаг ба дүрмийг Ажлын хэсэг баталдаг. Энэ чиг үүргийн хүрээнд банкны засаглалын зарчим, эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоо нь банкны тогтвортой, урт хугацааны үр ашигтай бизнесийн үйл ажиллагаанд зохистой бөгөөд нийцтэй байгаа эсэх баталгаажуулалтуудыг хийж ажиллаж байна. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн тайлангийн | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 102, SDG 12 |
| MS4.3 | | | Танай компани тогтвортой байдал/хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу? | | Тийм | | ХААН Банк нь 2018 оноос хойш Тогтвортой хөгжлийн тайланг тусад нь тайлагнасаар байна.<br>Дэлгэрэнгүйг ХААН Банкны цахим хуудаснаас үзнэ үү. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 102, SDG 12 |
| MS5.1 | | Тогтвортой байдлын тайлагнал | Танай компани олон улсын уур амьсгалын эрсдэлийн стандартын дагуу тайлагнадаг уу? | | Үгүй | | | ТХ-ийн 17 зорилго, Даян дэлхийн гэрээний 10 зарчим, ТоС-ийн 8 зарчмын хүрээнд 2019 оноос хойш тайлагнаж байна. 2023 онд банк Эрсдэлийн удирдлагадаа Уур амьсгалын эрсдэлийг тодорхойлон оруулсан ба цаашид уг эрсдэлийг удирдах төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. | GRI 102, SDG 12 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| MS5.2 | | | Тогтвортой хөгжлийн болон БОНЗ-ын мэдээллийг хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулдаг | | Үгүй | | | Банк одоогоор Тогтвортой хөгжлийн тайланг өөрийн санаачилгаар бэлтгэн оролцогч талуудад хүргүүлж байгаа бөгөөд цаашид хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулан тайлагнахаар зорин ажиллаж байна. | GRI 102, SDG 17 |
| MS5.3 | | Гишүүнчлэл, хамтын ажиллагаа | Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу? | | Тийм | | 1) НҮБ-ын Даян дэлхийн гэрээ (UN Global Compact)<br>2) Ногоон хөрөнгө оруулалтын зарчмууд (Green Investment Principles)<br>3) Монголын Тогтвортой санхүүгийн холбоо<br>4) МҮХАҮТ-ын дэргэдэх КНХ ба Тогтвортой хөгжлийн зөвлөл<br>5) Монгол дахь Америкийн худалдааны танхимын КНХ-ын хороо<br>*2023 оноос эхлэн:<br>6) НҮБ-ын Хүүхдийн сан<br>7) PCAF | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 102, SDG 17 |
| MS6.1 | **Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд** | | | | | | | | |
| E1.1 | Эрчим хүч | Нийт эрчим хүчний хэрэглээ | Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал | 2421001 | 2972547 | кВт.ц | ХААН Банкны төв оффис болох ХААН Банк цамхагийн хувьд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-иас нийт цахилгааны хэрэглээгээ авдаг бөгөөд 2022 онд 2.5 сая кВт.ц цахилгаан зарцуулсан. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн тайлангийн 71-р хуудаснаас үзнэ үү. | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 302, SDG 12 |
| E1.2 | | Цахилгаан | Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр) | 2421001 | 2972547 | кВт.ц | ХААН Банкны төв оффис болох ХААН цамхагийн хувьд Ковид цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор ажилтнуудын тодорхой хувь нь зайнаас ажиллаж байсан. 2022 онд хэвийн горимд шилжсэн тул хэрэглээ 5% нэмэгдсэн.<br>Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн тайлангийн 71-р хуудаснаас үзнэ үү. | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 302, SDG 12 |
| E1.3 | | Дулаан | Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр) | 12091 | 12174.5 | Төг/гДж | ХААН Банкны төв оффис болох ХААН Банк цамхагийн хувьд хэрэглээнээс үл хамаарах буюу талбайн хэмжээнээс хамаарсан тогтмол дүн. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн тайлангийн 71-р хуудаснаас үзнэ үү. | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 302, SDG 12 |
| E1.4 | | Түлш | Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр) | 484 | 505 | Литр/кг | ХААН Банкны төв оффис болох ХААН Банк цамхагийн хувьд нөөц цахилгаан үүсгэврийн түлш зарцуулалтын мэдээлэл | 2023 онд банк Төв оффисын өдөр тутмын хэрэглээнд 5 цахилгаан автомашин нэвтрүүлж эхэлсэн ба хэмнэлт, тооцооллыг хийн ажиллаж байна. | GRI 302, SDG 12 |
| E1.5 | | Хүрэн эрчим хүч | СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь | - | - | % | | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | SFRD |
| E1.6 | | Сэргээгдэх эрчим хүч | СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь | - | - | % | | 2023 онд банк өөрийн үйл ажиллагаанд СЭХ-ийг нэвтрүүлж, тооцоолол хийж эхэлсэн. | GRI 302, SDG 7 |
| E2.1 | | 3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт | Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн | - | 280.6 | CO2/тонн | 2022 оны төв банкны үйлчилгээнд ажилласан автомашины шатахуун зарцуулалтыг жишиг коэфицентээр тооцсон. /1 литр*2.3 кг CO2/ | 2023 онд банк Төв оффисын өдөр тутмын хэрэглээнд 5 цахилгаан автомашин нэвтрүүлж эхэлсэн ба хэмнэлт, тооцооллыг хийж ажиллаж байна. | GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| E2.2 | **Хүлэмжийн хийн ялгарал** | 3.2 Бууруулсан хүлэмжийн хий | Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр) | - | - | $CO_2$/тонн | | 2023 онд банк PCAF-д нэгдсэн, СЭХ болон бусад хүлэмжийн хийг бууруулах санаачилгуудыг нэвтрүүлсэн ба цаашид шууд болон шууд бус үйл ажиллагааны ялгаруулсан хүлэмжийн хийн тооцооллыг тодорхой тооцохоор зорин ажиллаж байна. | GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol. |
| E2.3 | | 3.3 Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/ | Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээны (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмийн хийг бууруулах гадны төслийг дэмжих гэх мэт)бууралт | - | 183.75 | $CO_2$/тонн | ХААН Банк сан нь 2021 оноос Улаанбаатар хотын дундуур урсах Сэлбэ голын эх, Их баяны ам орчимд нөхөн сэргээлт нэн шаардлагатай 40 га газрыг ойжуулах ажлыг эхлүүлсэн. 2022 онд 7 га талбайд 8,750 ширхэг мод тарьсан. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol. |
| E3.1 | **Уур амьсгалын өөрчлөлт** | Уур амьсгалын бодлого, журам | Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу? | | Үгүй | | | 2023 онд банк Эрсдэлийн удирдлагадаа Уур амьсгалын эрсдэлийг тодорхойлон оруулсан ба цаашид уг эрсдэлийг удирдах төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. | GRI 201, TCFD, SDG 13 |
| E3.2 | | Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ | Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү? (сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт) | | Тийм | | 2019 онд стресс тестийн үнэлгээ, сценари шинжилгээ хийсэн ба үүнийг цаашид тогтмол хийж үр дүнг үйл ажиллагаанд тусгах, хэрэгжилтийг хангаж ажиллахаар зорьж байна. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 201, TCFD, SDG 13 |
| E3.3 | | Эдийн засгийн хохирол | Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ | | - | Төгрөг | | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 201, TCFD, SDG 13 |
| E3.4 | | Уур амьсгалын хөрөнгө оруулалт | Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн | | | Төгрөг | | 2023 онд хэрэгжүүлсэн төслүүдийн мэдээллээр тайлагнах боломжтой байна. | GRI 201, TCFD, SDG 13 |
| E3.5 | | Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох | Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон уу? | | Үгүй | | | 2023 онд ХААН Банк Эрсдэлийн удирдлагын тогтолцоонд Тогтвортой хөгжлийн бодлого болон банкны үйл ажиллагаа, ашигт сөргөөр нөлөө үзүүлж болзошгүй уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх эрсдэлийг тусган "Бүх чиглэлд уур амьсгалын нөлөөллөөс үүдэн гарах эрсдэлийг анхаарч үздэг байх, холбогдох тооцоолол судалгааг хийн удирдах" шийдвэрийг гарган, төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | GRI, SASB, World Economic Forum |
| E4.1 | **Ус** | Усны хэрэглээ | Ашигласан усны нийт хэмжээ | 12,463 | 18,159 | м3/Л | Төв банкны хувьд цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор ажилтнуудын тодорхой хувь нь зайнаас ажиллаж байсан. 2022 онд хэвийн горимд шилжсэн тул хэрэглээ 2021 онтой харьцуулахад нэмэгдсэн. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн тайлангийн 71-р хуудаснаас үзнэ үү. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 303, SDG 6 |
| E4.2 | | Хэмнэсэн ус | Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ | - | - | м3/Л | | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 303, SDG 6 |
| E4.3 | | Дахин боловсруулсан ус | Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь | - | - | % | | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 303, SDG 6 |
| E4.4 | | Хаягдал бохир ус цэвэрлэх | Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ | - | - | м3/Л | | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 303, SDG 6 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| E5.1 | **Хатуу хог хаягдал** | Хог хаягдал | Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ | - | 24.6 | тонн | 2022 онд банк төв оффисын хэмжээнд хогны менежментийг шат дараатай хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу ажилласан ба нийт ялгаруулж буй хог хаягдлыг хэмжиж, ангилж, дахин боловсруулах үйлдвэрүүдтэй хамтран ажиллах болон нийт ажилтнуудад сургалт, мэдээлэл хүргэн ажиллаж эхэлсэн. | 2023 онд хог хаягдлын менежментийн тоон мэдээллийг бүртгэх, тооцох ажлууд хийгдэж байгаа бөгөөд тайлант хугацаагаар мэдээлэл тайлагнах боломжтой. | GRI 306, SDG 12 |
| E5.2 | | Дахин боловсруулсан хатуу хог хаягдал | Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь | - | - | % | | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 306, SDG 12 |
| E5.3 | | Хортой хог хаягдал | Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно) | - | - | тонн | Тайлант хугацаанд хортой хог хаягдал цахилгаан хэрэгслийн хаягдал байхгүй. Ашиглалтаас гарсан буюу актлагдсан электрон тоног төхөөрөмжүүдийг хандивлах, ажилтнуудад худалдан борлуулдаг. | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 306, SDG 12 |
| E6.1 | **Биологийн олон янз байдал** | Ногоон байгууламж, төлөвлөлт | Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь | 30 | 30 | % | Төв банкны гадна ландшафтаас ногоон байгууламж буюу зүлэг, мод, бут суурилуулсан хэсгүүдийнхээ талбайг хэмжсэн болно. | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 304, SDG 15 |
| E6.2 | | Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах | Хамгаалсан төрөл зүйлийн тоо | | | Төрөл зүйлийн тоо | | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 304, SDG 15 |
| E6.3 | | Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа | Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь | - | - | % | | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | SFRD, IFC Performance Standard 6 |
| | **Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд** | | | | | | | | |
| S1.1 | **Хүний нөөц** | Хүний нөөцийн тогтвортой байдал | Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах) | 14.9 | 16.9 | % | 2022 онд өмнөх онтой харьцуулахад гаралт 15%-иар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс үүдэн эргэц 2%-иар өссөн байна. | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 401, SDG 8 |
| S1.2 | | Шинээр бий болгосон ажлын байр | Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо | 11 | 102 | Тоо | 2022 онд 102 ажлын байр шинээр бий болгосон. Өмнөх оны үзүүлэлтээс 9.2 дахин өссөн байна. | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 401, SDG 8 |
| S1.3 | | Сургалт | Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг | | 127.7 цаг | цаг | Цахим сургалтын хувьд 255.2 цагийг зарцуулдаг ба үүнд техник ур чадвар, хувь хүний хөгжлийн зэрэг бүх төрлийн сургалт байдаг. Танхимын сургалтын хувьд 23 минутыг дунджаар ноогддог байна. Дээрх сургалтын цагуудыг гаргахдаа нэгж ажилтны бүтэн жилд суралцдаг цаг дээр үндэслэн тооцоолов. | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 401, SDG 8 |
| S2.1 | | ХАБЭА-н бодлого | ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? | | Тийм | | ХААН Банкны Эрсдэлийн удирдлагын хорооны 2020 оны 10-р сарын 16-ны өдрийн шийдвэрээр "ХААН Банкны аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого" батлагдсан ба захирлын 2021 оны 4-р сарын 8-ны өдөр "ХААН Банкны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах үйл ажиллагааны журам" батлагдсан.<br>"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг түр зөвлөл"-ийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд улирал бүр тогтмол хуралдаж ажлаа тайлагнаж хэвшсэн. УБ болон орон нутгийн салбаруудад түр зөвлөлийг 3-5 ажилтны бүрэлдэхүүнтэй байгуулсан. ХАБЭА-г хангах чиглэлээр дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 103, SDG 10 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| S2.2 | **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)** | Осол аваар | Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь | | 0,2 | % | 2022 онд нийт 4 тохиолдлыг үйлдвэрлэлийн осолд бүртгэсэн. Аливаа аюул, ослоос урьдчилан сэргийлэх, анхааруулах чиглэлээр төрөл бүрийн зааварчилгаа, зөвлөмжийг шат дараатай танилцуулж хэвшсэн. Үйлдвэрлэлийн осол, осол дөхсөн тохиолдол бүртгэх ERP системээр автоматжуулсан. Ажлын байран дээрх бүх төрлийн аюул, осол, бэртлийг бүртгэж гарсан эмчилгээний зардлыг банк болон даатгалын байгууллагаас нөхөн олгодог. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү | GRI 403. SDG 3 |
| S2.3 | | ХАБЭА-н сургалт | Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг | | 90 | минут | ХАБЭА тухай хууль, ХААН Банкны ХАБЭА бодлого, журмын хэрэгжилтийг хангах үүднээс жилд 2 удаа заавал хамрагдах сургалтыг ХААН Банк Академи буюу дотоодын цахим сургалтын платформоор зохион байгуулж хэвшсэн. Нийт ажилтны 90%-иас дээш ажилтан сургалтад хамрагдсан. Сургалтад хамрагдсан ажилтнуудад сертификат олгодог. Нийт ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ажилтнуудынхандах боломжтой цахим сувгуудаар цуврал зөвлөмж, видео хичээлийг тогтмол бэлтгэн хүргэж байна. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 403. SDG 3 |
| S2.4 | | Эрүүл мэндийн хөтөлбөр | Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр | | 1,213 | хүн | 1. Эмчийн өдөр тутмын ажилтнуудад үзүүлсэн үйлчилгээ - Давтагдсан тоогоор 1,213<br>2. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг - 671 ажилтан сайн дураар хамрагдсан<br>3. Эрүүл мэндийн даатгал - 357 ажилтан сайн дураар хамрагдсан<br>4. Сэтгэл зүйчийн ганцаарчилсан уулзалт - 1,065 давхардсан тоогоор<br>5. Сэтгэл зүйчийн бүлгийн сургалт - 95 удаа<br>6. Бариа заслын үйлчилгээ - 3,501 ажилтан хамрагдсан.<br>7. Ажлын байран дээрх бариа ҳаслын үйлчилгээ - 552 ажилтан<br>8. КОВИД түргэвчилсэн шинжилгээнд нийт 7,274 ажилтан | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү | GRI 403. SDG 3 |
| S3.1 | **Эрх тэгш байдал** | Жендэрийн бодлого, журам | Жендэрийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? | | Тийм | | 2022 оны 9-р сарын 28-ны өдөр батлагдсан "ХААН Банкны хөдөлмөр эрхлэлтийн эрх тэгш байдлыг хангах тухай бодлого"-д жендэрийн талаар баримтлах бодлогыг тусгасан. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 405, SDG 5 |
| S3.2 | | Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам | Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? | | Тийм | | Ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, энэ талаарх гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам 2022 оны 8-р сарын 19-нөөс эхлэн хэрэгжиж байна. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 103, SDG 5 |
| S3.3 | | Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам | Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? | | Тийм | | 2022 оны 9-р сарын 28-ны өдөр батлагдсан "ХААН Банкны хөдөлмөр эрхлэлтийн эрх тэгш байдлыг хангах тухай бодлого"-д ялгаварлан гадуурхалтын эсрэг баримтлах бодлогыг тусгасан. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 103,SDG 10 |
| S3.4 | | Ажилтнуудын хүйсийн харьцаа | Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь | 33/67 | 33/67 | % | Нийт ажилтны 33% нь эрэгтэй, 67% эмэгтэй ажилтан байна. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү | GRI 405, SDG 5 |
| S3.5 | | Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа | Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа | 75/25 | 78/22 | % | ТУЗ-ийн гишүүдийн 78% нь эрэгтэй, 22% нь эмэгтэй байна. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 405, SDG 5 |
| S3.6 | | Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа | Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа | 58/42 | 62/38 | % | Гүйцэтгэх удирдлагын 62% нь эрэгтэй, 38% нь эмэгтэй байна. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү | GRI 405, SDG 5 |
| S3.7 | | Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа | Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа | 33/67 | 32/68 | % | Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын 32% нь эрэгтэй, 68% нь эмэгтэй байна. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 405, SDG 5 |
| S3.8 | | Жендэрт суурилсан цалингийн зөрүү | Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа | | 31/35 | харьцаа | Монгол Улсын хэмжээнд 2022 оны дундаж цалин (хүйс) - тай харьцуулснаар ХААН Банкны дундаж цалин нь эрэгтэй 31%-иар, эмэгтэй 35%-иар тус тус өндөр байна. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 405, SDG 5, SFRD |
| S4.1 | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? | | Тийм | | 2022 оны 09-р сарын 28-ны өдөр батлагдсан "ХААН Банкны хөдөлмөр эрхлэлтийн эрх тэгш байдлыг хангах тухай бодлого"-д олон талт ялгаа байдал, үүн дотроо хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүндэтгэх, энэ талаар баримтлах бодлогыг тусгаж өгсөн. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | SDG 10 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| S4.2 | Хүртээмжтэй байдал | Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд | Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь | 2.29 | 1.6 | % | 2021 оноос Монголын хараагүйчүүдийн төвийн харьяа хөгжлийн бэрхшээлтэй бариач нарыг ажиллуулж, ажилтнуудад барианы үйлчилгээ үзүүлдэг болсон ба 2022 оноос худалдан авах гэрээгээр тус үйлчилгээг авч гэрээний төрөл өөрчлөгдсөн. | | SDG 10 |
| S4.3 | | Оффисын хүртээмж | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу | | Тийм | | дагуу банкны эзэмшлийн бүх барилгууд налуу замтай хийгдсэн байдаг. Төв оффисын хувьд ОУ-ын оффисын А зэрэглэлийг хангасан стандарттай учир налуу зам, тэргэнцэртэй иргэн орж гарахад зориулсан хаалга, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусдаа ариун цэврийн өрөө гэх мэт ерөнхий шаардлагууд бүгд хангагдсан байдаг. | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | SDG 10 |
| S4.4 | | Торгууль | Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо | | | Төгрөг | Зөрчил байхгүй. | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | SDG 10 |
| S5.1 | Нийгмийн хариуцлага ба ил тод байдал | Оролцогч талуудын оролцооны засаглал | Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу? | | Үгүй | | | 2024 онд тодорхой төлөвлөгөөт ажлууд хийхээр зорин ажиллаж байна. | IFC |
| S5.2 | | Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого | Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана) | | Үгүй | | | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | IFC Performance Standards |
| S5.3 | | Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/журам | Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу? | | Тийм | | Эрсдэлийн хорооны шийдвэрээр 2022 оны 1-р сард нэмэлт өөрчлөлт оруулж "Харилцагчийн гомдол хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх үйл ажиллагааны журам"-ыг баталсан. Олон улсын ISO:9001 болон ISO:10002 стандартыг дагуу хэрэгжүүлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ХААН Банкны вэбсайтаас үзнэ үү. | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 102, SDG 16 |
| S5.4 | | Олон нийтэд ил тод мэдээлэх | Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу? | | Тийм | | Гүйцэтгэх захирлын 2017 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 02/15 тоот тушаалаар батлагдсан "Харилцагчийн гомдол хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх үйл ажиллагааны журам"-ыг мөрдөж ажилладаг. Бид гомдлыг доорх сувгуудаар хүлээн авч шийдвэрлэдэг:<br>1. Салбар, тооцооны төв дээр<br>2. 18001917 дугаараар<br>3. khanbank.com вэб хаягаар<br>4. Аппликэйшнээр<br>5. Сошиал сувгаар<br>6. Өргөдөл, маягтаар | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | IFC Performance Standards |
| S5.5 | | Ажилчид/олон нийтийн санал гомдол | Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдэрлэсэн хувь | | 94 | % | Нийт хүлээн авсан гомдлыг 100% шийдвэрлэн ажилласан ба үүнээс 94%-ийг хяналтын хугацаанд шийдсэн. Та бүхэн асуулгадаа аль тохирох хувилбарыг ашиглаарай. Банкны ажилтнуудаас ирсэн санал гомдлыг цаг тухай бүрд нь шийдвэрлэж, хамтран ажилладаг. | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 413, SDG 8 |
| S5.6 | | Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт | Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь | | 0.43 | % | ХААН Банк байгуулагдсан цагаас хойш Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд төсөл хөтөлбрүүдийг хэрэгжүүлсээр байна. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн тайлангийн 76-р хуудаснаас үзнэ үү. | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 413, SDG 8 |
| S6.1 | Тогтвортой өртгийн | Худалдан авалтын бодлого, журам | Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжыг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? | | Тийм | | Худалдан авалтын бодлого, Худалдан авалтын журмыг дотооддоо мөрдөн ажилладаг. Тус журманд ХААН Банкны Тогтвортой хөгжлийн бодлогыг дагаж мөрдөж худалдан авалт хийх заалт тусгагдсан байдаг. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн тайлангийн 70-р хуудаснаас үзнэ үү. | | GRI 204, SDG 8 |
| S6.2 | | Дотоодын худалдан авалт | Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь | | 87 | % | Нийт 449 нийлүүлэгчээс худалдан авалт хийснээс 390 нь дотоодын харилцагч байна. | *мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.* | GRI 204, SDG 8 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| S6.3 | сүлжээний менежмент | Тогтвортой, ногоон худалдан авалт | Нийт хангагч нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон хангагч нийлүүлэгчдийн хувь | | 14 | % | Хангагч нийлүүлэгчийг сонгохдоо тогтвортой буюу нийгмийн хариуцлагын талаарх шалгуурын асуулгыг /гуравдагч талын асуулга дээр 2021 оны 1-р нэмсэн/ авдаг бөгөөд тухайн шалгуурыг хангаж буй нийлүүлэгчийн эрсдэлийн түвшинг үнэлж шийдвэр гаргадаг. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 204, SDG 8 |
| | **Засаглалын шалгуур үзүүлэлтүүд** | | | | | | | | |
| G1.1 | **Авилгал болон ёс зүй** | Авилга, хээл хахуулийн эсрэг бодлого журам | Авилгын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу? | | Тийм | | ХААН Банкны Авлига, хээл хахуультай тэмцэх бодлогыг 2020 оны 2-р сарын 17-ны өдөр баталсан. Бодлогын баримт бичгийг олон улсын стандарт, дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан бөгөөд Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд баримтлан ажиллаж байна. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 205, SDG 16 |
| G2.1 | **Компанийн засаглал** | Удирдах зөвлөлийн хараат бус байдал | Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь | | 33 | % | | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 102, OECD Principles of Corporate |
| G2.2 | | Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх | Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу? | | Тийм | | https://www.khanbank.com/uploaded/static_files/documents/20230629%20ENG%20KB%20JSC%20Charter.pdf | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16 |
| G2.3 | | Компанийн засаглалын бодлого, журам | Компанийн засаглалын бодлого, журам бий юу? | | Тийм | | https://www.khanbank.com/uploaded/static_files/documents/20230629%20ENG%20KB%20JSC%20Charter.pdf | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16 |
| G3.1 | **Комплайнс** | Комплаенсын бодлого | Комплаенсын бодлого, журам бий юу? | | Тийм | | ХААН Банк нь МУТСТ олон улсын стандарт, зарчмуудыг дотоод бодлого журамдаа тодорхойлон тусгасан байдаг бөгөөд үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Бодлого, журамд жил бүр хяналт тавьж, хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын дүрэм журам, удирдамж шинэчлэгдэх тухай бүр нийцүүлэн, тогтмол шинэчлэх арга хэмжээг авдаг. Дэлгэрэнгүйг ХААН Банкны вэбсайтаас үзнэ үү. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16 |
| G3.2 | | Комплаенсын хөтөлбөр | Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу? | | Тийм | | Банкны хэмжээнд дагаж мөрдөх Комплаенсын дотоод хяналтын хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд 2023-2025 оны хөтөлбөрийг банкны Гүйцэтгэх удирдлагаас баталсан. Комплаенсын хөтөлбөрийн дагуу МУТСТ, Харилцагч таньж мэдэх, хориг арга хэмжээний хяналтын тогтолцоог тогтмол сайжруулах, үр дүнтэй тогтолцоог бий болгох зорилгоор бодлого журамд өөрчлөлт оруулахын зэрэгцээ, дижитал шилжилт, үйл ажиллагааг автоматжуулах, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг банкны хэмжээнд хангуулан ажиллаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Банкны ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон улмаар Монголбанкинд тогтмол тайлагнан ажиллаж байна. Дэлгэрэнгүйг ХААН Банкны вэбсайтаас үзнэ үү. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16 |
| | **Нэмэлт салбарын шалгуур үзүүлэлтүүд (Танай компанид хамаарах салбарын асуултуудыг бөглөнө үү)** | | | | | | | | |
| FS1 | **Санхүүгийн үйлчилгээ** | Санхүүгийн хүртээмж | Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх болон санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах санаачилга, арга хэмжээнд оролцсон хүмүүсийн тоо, жилээр | | 16000 | хүн | Олон нийтийн санхүүгийн боловсрол, мэдээллийн аюулгүй байдлын тухай ойлголтыг дээшлүүлэх зорилгоор сар бүр тогтмол сошиал контент агуулга оруулж байна. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн тайлангийн 54-р хуудаснаас үзнэ үү. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | SDG 1 |
| FS2 | | БОНЗ-ын эрсдэлийн менежмент | БОНЗ-ын эрсдэлийн шалгуур болон хориотой үйл ажиллагааны жагсаалтаар үнэлсэн гүйлгээний хувь | - | 7.91 | % | 2022 онд зээлийн дүнгээр нийт багцын 7.91 хувьд буюу 629.2 тэрбум төгрөгийн 200 зээлийн хүсэлтэд БОНЗЭҮнэлгээ хийгдсэн байна. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | Mongolian Sustainable Finance Principles |
| FS3 | | Тогтвортой санхүүжилт | Нийт зээлийн багцад эзлэх ногоон/ТХЗ таксономийн ангилалд нийцсэн ногоон/тогтвортой зээлийн эзлэх хувь | - | 1.049 | % | 2022 оны төгсгөлд ХААН Банк 104.9 тэрбум төгрөгийн ногоон зээлийн багцыг бүрдүүлээд байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн багц 106.87%-ийн өсөлттэй байна. Дэлгэрэнгүйг ХААН Банкны Тогтвортой хөгжлийн тайлангийн 48-р хуудаснаас үзнэ үү. | мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү. | SDG 13, Mongolia Green Taxonomy |